

АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт үйл ажиллагаа	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Эх үүсвэр	Хөрөнгийн хэмжээ /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилт ийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая.төг)	Гүйцэтгэл (сая.төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
<b>Бүлэг 1. "КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ</b>												
Зорилго 1.1. "Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.												
1	АЗДҮАХ 1.2.1.1	Цар тахлын үед ажилласан албан хаагчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	2022	АЗДТГ-ын СТСХ	СЯТ	70.0	20 албан тушаалтан	30-аас доошгүй албан тушаалтанд олгоно.	70.0	134.6	Эрүүл мэндийн даатгалын сангаас 2022 оны 1 сард Ковид-19" халдварт өвчний үед улаан бүсэд ажилласан 126 эмч, эмнэлгийн мэргэжилтэнд нэмэлтээр 134.6 сая төгрөгийн урамшуулал цалин, илүү цагийн хөлс олгогдсон.	100
2	АЗДҮАХ 1.2.1.2	Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн хүнсний бүтээгдэхүүн, эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн болгосын	2022	АЗДТГ-ын НБХ	СЯТ	50.0	10 нэр төрлийн хамгаалах хэрэгсэл худалдан авсан.	12 нэр төрлийн хамгаалах хэрэгсэл худалдаж авна.	50.0	575.6	Гамшгийн үеийн бэлэн байдал эм тариа 14 нэр төрлийн 252.5 сая төгрөг, эмнэлгийн хэрэгсэл 24 нэр төрлийн 213.2 сая төгрөг, оношлуур 109.9 сая төгрөг, нийт 575.6 сая төгрөгийн нөөцийг бүрдүүлсэн. 2022 оны ЭМС-ын А/134, А/196 тоот тушаалаар 202.0 сая төгрөгийн хамгаалах хувцас хэрэгсэл, 117 нэр төрлийн 261.1 сая төгрөгийн эм эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодисыг сумын эрүүл мэндийн төвүүдэд хүргүүлсэн байна.	100
Дүн											100	
<b>НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН</b>											<b>100</b>	
<b>Бүлэг 2. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>												
Зорилго 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.												
3	АТЖҮЧ 2.2.2 АЗДҮАХ 2.1.4.1.	"Чадварлаг эмч" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	100.0	Арга хэмжээ боловсруул агдсан	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	100	41.5	Чадварлаг эмч" арга хэмжээг 4 зорилт, 37 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна. АШУҮИС-ийн багш шавийн уулзалтыг зохион байгуулсан. Аймгийн НЭ-ийн дотрын тасгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 15.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлж засвар хийж тохижуулж, ОНХС-гийн дэмжлэгээр шаардлагатай багаж тоног төхөөрөмжөөр хангасан. Шастины клиникийн III төв эмнэлэгтэй хамтран ажиллах гэрээний дагуу зурх, тархины мээ засал, мэдрэлийн эмч, ерөнхий мээ заслын эмчийн бүрэлдэхүүнтэй баг 10 дугаар сард 3 хоног ажиллаж доод мөчдийн венийн бүдүүрлийн мээ засал-4, цөсний мээ засал-2, тархины мээ засал-1 -ийг хийж мэдрэл, зүрхний эмчийн үзлэгийг 54 иргэнд үзүүлсэн байна. ЭМЯ-наас аймгийн Нэгдсэн эмнэлгийн мээ заслын тасгийг 200 сая төгрөгийн үнэ бүхий урологийн доод замын дурангийн багаж тоног төхөөрөмжөөр хангаж, УНТЭ-н хагалгааны баг аймгийн НЭ-т ажиллан, бөөр шээсний доод замын дурангийн хагалгааг 9 иргэнд хийж, эмч сувиллагч нарыг ажлын байранд сургасан. АНЭ-т урологийн мээ заслууд хийгдэх бүрэн боломж бүрдэж 10 сарын байдлаар шээсний сүвний нарийсал тэлэх мээ засал 1, давсагны уян дурангийн оношилгооны 4 тохиолдлыг хийсэн байна. Хавдрын үеийн хими эмчилгээг тогтмол хийж 10 дугаар сарын байдлаар хавдрын хяналтад 699 хүн хянагдаж, давхардсан тоогоор 28 хүнд хими эмчилгээ хийсэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт гемодиализийн тасгийг байгуулснаар бөөр арга дутагдалтай 2-10 иргэнд тогтмол эмчилгээнд орж байна. Аймгийн Засаг дарга ковид 19 халдварын үеийн тусламж үйлчилгээг үр дүнтэй хэрэгжүүлсэн эмч сувиллагчийг шагнаж Засаг даргын нөөц сангаас 11.5 сая төгрөгийг зарцуулсан. Чадварлаг хамт олон"-оор Цэцэн-Уул, Баянтэс, Тэс сумын Эрүүл мэндийн төв, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг, "Одчим-Наран" эмнэлэг, аймгийн Нэгдсэн эмнэлгийн Мэдрэлийн тасаг, "Чадварлаг баг" –аар аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн тасгийн "Чих хамар хоолойн" кабинет шалгарч тус бүр 4000,000 сая төгрөг нийтдээ 25.0 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.	100
4	АЗДҮАХ 2.1.2.2	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулж урамшуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	8.0	83	88	8.0	8.0	ЭМДБ шалгаруулах ЭМС-ын 2017 оны А/472 –р тушаал, аймгийн Засаг даргын 2022 оны А/342 дугаар захирамжын дагуу "Эрүүл мэндийг дэмжих байгууллага", "Эрүүл ажлын байр"-ыг 4 чиглэл 24 шалгуур үзүүлэлтээр цахимаар дүгнэж шалгаруулсан. 2022 онд 3 зэргийн болзолыг 8 байгууллага шинээр хангаж, 14 байгууллага зэргээ ахиулснаар аймгийн хэмжээнд Эрүүл мэндийг дэмжигч 93 байгууллагатай боллоо. Эрүүл ажлын байр 4 байгаагаас 2022 онд 1 байгууллага зэргээ ахиулсан байна. Энэхүү зорилтод ажилд 12 сумын 22 байгууллага хамрагдаж байгаа бөгөөд эдгээр сумдын 39,104 иргэн эрүүл мэндийн боловсролын талаар мэдээллийг бүрэн авч байгаа төдийгүй 3867 иргэн эрүүл зан үйл, эрүүл амьдралын хэв маягийг хэвшүүлж байгаа үр дүн харагдаж байна. Эдгээр байгууллагуудын шагнал, урамшуулалд зарцуулагдах 8,0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/521 дугаар захирамжаар гаргаж шагналыг олгосон.	100
5	АТЖҮЧ 2.2.1 АЗДҮАХ 2.1.2.1	Эх, хүүхдийн эрүүл мэнд, халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, бууруулах, бага насны хүүхдийн өвчлөлийг эрт илрүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	50.0	1	3 арга хэмжээ хэрэгжүүлнэ.	50.0	50.0	Улиастай сумын ЕБ-ын 5 сургууль, Хөгжим бүжгийн коллежийн 9 дүгээр ангийн 512 суралцагчийг үзлэгт хамруулахаас 136 хүүхдийг үзлэгт хамруулсан. Мөн Их-Уул сумын ЕБ-ын сургуульд 1469 суралцагч бүртгэлтэй байгаагаас 9,10 дугаар ангийн 216 хүүхэд, Улиастай сумын 5 сургууль, ХБК-ийн үзлэгт хамрагдаагүй үлдсэн 376 хүүхдүүдийг тус тус урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 16-наас 12 дугаар сарын 5-ны өдрийн хугацаанд зохион байгуулахаар удирдамжийг баталж 25.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Төрөх тасгийн дулаалга хийхэд 15,0 сая, аймгийн НЭ-ийн хөнгөвчлөх эмчилгээний тасагт хавдрын үеийн хими эмчилгээний өрөөг тохижуулахад 10,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн.	100

6	АЗДҮАХ 2.1.4	Эрүүл мэндийн салбарт хийгдэж буй "Эрдэм шинжилгээ, судалгаа"-ны ажлыг олон улсын хэмжээнд	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	2.0	-	Scopus Pubmed -д бүртгэлтэй эрдэм шинжилгээний бүтээл гаргасан	2.0	2	Аймгийн Засаг даргын 2022 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 347 дугаар захирамжаар 2,0 сая төгрөгийг гаргаж "Монголын Эрүүл мэнд" сэтгүүлд материалыг нийтэлсэн.	100
7	АЗДҮАХ 2.2.1.3	Нэгдсэн эмнэлэгт хөдөлгөөн засал, хөдөлмөр заслын эмчилгээний тоног төхөөрөмж авна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	9.0	-	3-аас дээш нэр төрлийн тоног төхөөрөмжөөр хангасан байна.	9.0	9.0	Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг худалдан авах ажлыг зохион байгуулсан. ХЭЙНБҮҮК ХХК-тай гэрээ байгуулан хөдөлмөр засал, хөдөлгөөн заслын (Бэхлэгээтэй алхуулагч /энгийн-1ш , 2. РТ –ийн дасгалын ор, гарын сарвуу тэнцүүлэгч, Goniometer, ОТ дасгалын ком, мөрний дасгалын төхөөрөмж, Л6. гарын хүч сайжруулах дасгал-1) 7 нэр төрлийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100
8	АТЖҮЧ 2.2.1 АЗДҮАХ 2.1.1.7	Зүрх, судасны тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ТХ	60.0	5 тоног төхөөрөмж	20 тоног төхөөрөмж	60.0	60	ХБӨ/Зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (PEN/HEARTS)-ыг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд амжилттай хэрэгжүүлж ажиллаж, төслийн хүрээнд 25 эрүүл мэндийн байгууллагад 5 нэр төрлийн 128.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжөөр хангасан. Зүрх судасны шалтгаант нас баралт өмнөх оны мөн үеэс 5 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй, зүрх судасны шалтгаант нас баралтын түвшин 16.2 байна. Тархины харвалт, зүрхний шигдээсийн нас баралт 30 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэтай харьцуулахад 2 тохиолдлоор буурсан үзүүлэлттэй байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн Зүрх судасны кабинет 3954 үзлэг хийсэн ба үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 443, Зүрхний цахилгаан бичлэг 3423, Зүрхний ЭХО 281, 24 цагийн зүрхний цахилгаан бичлэг 45, MNCARDIO программд 458 тохиолдолд тусламж үйлчилгээг хүргэн ажилласан байна.	100
9	АТЖҮЧ 2.2.1 АЗДҮАХ 2.1.1.9	Эрүүл мэндийн төвийн гал тогооны тоног төхөөрөмж /Тэлмэн сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	15.0	-	Гал тогооны тоног төхөөрөмж шинэчлэгдэнэ.	15.0	15	Тэлмэн сумын Эрүүл мэндийн төв нь хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж "ЧИГЛЭЛ" ХХК, "Чэйн Дон" ХХК нь гал тогооны тоног төхөөрөмжийг нийлүүлсэн 1, 2-р хоолны тогоотой болсноор хэвтэн эмчлүүлэгчдийн хоолны төлөвлөгөө, нормын дагуу хийхэд хялбар болж, сахар, бөөрний өвчтэй хүмүүст эмчилгээний хоолыг тогтмол өгч байна. хөргөгч, хөлдөөгчтэй болсноор хүнсний ногоо муудахаас сэргийлэх, хүнсний нэр төрлөөр хадгалах боломж бүрдсэн. Хоолны дээжний хөргөгчтэй болсноор 3 өдрийн дээжийг хадгалж, ариутгагчтай хатаагч нь өвчтөн хооронд дамжих ахуйн халдварыг бууруулах боломжтой байна.	100
10	АТЖҮЧ 2.2.1 АЗДҮАХ 2.1.1.9	Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлгийг нярайн амьсгалын аппаратаар хангана.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	40.0	-	1 аппаратай болсон байна.	40.0	40.0	Ай-Мед ХХК тендэрт шалгарч аппаратыг 2022 оны 7 дугаар сард нийлүүлсэн. Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт 28 долоо хоногтой нярайд бүрэн ашиглаж эмчилгээний үр дүн 100 хувь гарсан. Цаашид дутуу нярайд үзүүлэх яаралтай тусламжийн бэлэн байдал хангагдаж байгаагаар ач холбогдолтой.	100
11	АТЖҮЧ 2.2.1 АЗДҮАХ 2.1.1.6	Багийн эмч нарыг унаажуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	30.0	-	10 багийн эмч	30.0	30.0	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 30.0 сая төгрөгийн үнэ бүхий мотоциклийг Алдархаан сумын Чигэстэй баг, Баянтэс сумын Жавхлан, Сонгино сумын Айраг, Тэс сумын Дооно, Шилүүстэй сумын Баян-улаан, Цагаанчулуут сумын Арц, Дөрвөлжин сумын Буурал, Их-уул сумын Зарт, Цагаанхайрхан сумын Баянбулаг, Идэр сумын Загастай 10 багийн эмч нарт олгосон.	100
<b>Дүн</b>												<b>100.00</b>
Зорилго 2.2.Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, олимпын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ.												
12	АЗДҮАХ 2.2.1.3	"Хөдөлгөөн-Эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	Арга хэмжээ боловсруул агд сан. (1)	4-өөс доошгүй арга хэмжээ	5.0	5.0	"Хөдөлгөөн-Эрүүл мэнд" арга хэмжээг боловсруулан 4 зорилт 33 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилтийн хүрээнд бий биелэгээ, шугаман бүжгийг 23 суманд хийж хэвшүүлээд байна. Атка-дансе бүжгийн клуб нь Монгол Улсын бүжгийн спортын холбоотой хамтран 14 суманд спорт бүжгийн сургагч 59 багшийг бэлдэж, 1659 хүн спорт бүжгийн сургалтад хамрагдсан байна. 300 хүний оролцоотой флашмоё, 500 оролцогчийн бий биелэгээг хийж, уралдаан тэмцээнүүдийг тогтмол явуулж байна. Судалгаа авч нэгтгэхэд: Нийт хүн амын 67 хувь нь өдөр тутамдаа эрүүл амьдрах дасгал, хөдөлгөөн, иог, бясалгал, уулын алхалт, өглөөний алхалт, унадаг дугуйн аялал зэрэг спортын аль нэг төрлөөр хичээллэдэг болсон байна. Цэцэрлэг, сургуулийн нийт суралцагчдын 83% нь өдөр тутам дасгал хөдөлгөөн хийж, ЕБ-ын 18 сургууль их завсарлагааны дасгалыг тогтмол хийж хэвшсэн байна. Иргэдэд үйлчлэх нийтийн спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр аймгийн хэмжээнд нийтийн биеийн тамирын болон хүүхдийн гадаа тоглоомын талбай 35, тоног төхөөрөмжөөр хангагдсан баялдэрхуулах кабинет 16 ашиглагдаж байна. Арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөлд тавьсан. Зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлж иргэдийн дунд идэвхтэй хөдөлгөөнийг өрнүүлэх тухай аймгийн Засаг даргын 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн А/544 дүгээр захирамж гарч иргэдийг идэвхтэй хөдөлгөөн хийх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зориулан биеийн тамирын заалыг өглөө бүр 6:00-8:00 цагийн хооронд ард иргэддээ зориулж нээлттэй байлган үнэ төлбөргүй үйлчлэхийг байгууллагын дарга нарт үүрэг болгож, иргэдийг идэвхтэй хөдөлгөөн хийхийг уриалан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100
13	АЗДҮАХ 2.2.1	Бус, улс, олон улсын чанартай тэмцээнд амжилт гаргасан дасгалжуулагч, тамирчдыг урамшуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	18.0	55	10-аас доошгүй тамирчин, дасгалжуулагч	18.0	18	Аймгийн Засаг даргын 2022 оны 302 дугаар захирамжаар улс, бүсийн спортын тэмцээнд амжилттай оролцож медаль авсан өсвөрийн тамирчид, 2021-2022 оны хичээлийн жилд сурлага, урлагаар амжилт гаргасан суралцагчид, багш,дасгалжуулагч 29 хүнд 2.800.000 мянган төгрөгийн шагнал урамшууллыг олгож, аймгийн Засаг даргын "Талархал" хадгалуулсан. Монголын бүх ард түмний XV наадам, үндэсний спортын VII наадмын 5 төрөлд медаль авсан 26 тамирчин, дасгалжуулагчид 1.7 сая төгрөгийн урамшууллыг олгосон. 2022 оны үндэсний их баяр наадмаар улсын заан, улсын харцага цол авсан М.Лхагвагэрэл, Л.Лха-Очир нарт урамшуулал олгосон.	100

14	АЗДҮАХ 2.2.3.1	Сургууль түшиглэсэн бэлдэржуулах төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	5.0	0	3 сургууль	5	5	Улиастай сумын ЕБ-ын 3 дугаар сургууль нь бэлдэржуулах танхимыг байгуулж, Ундрах ХХК-тай гэрээ байгуулан 13 нэр төрлийн тоног төхөөрөмжийг суурилуулсан 2022 оны 11 дүгээр сараас үйл ажиллагаа явуулж эхлээд байна.	100
15	АЗДҮАХ 2.2.8	Цогцолбор сургуулийг түшиглэн биеийн тамирын төрөлжсөн салбар анги нээнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	0	1 сургууль	5	5	Цогцолбор сургуулийг түшиглэн биеийн тамирын төрөлжсөн салбар анги нээх үйл ажиллагаанд зарцуулагдах 5,000,000 (таван сая) төгрөгийг аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 16-ны А/559 тоот захирамжаар ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуульд олгосон.	90
16	АТЖҮЧ 8.3.4 АЗДҮАХ 3.7.3	Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын их засвар /Улиастай сум/	2022	АЗДТГ-ын ХОХБТХ	ОНХС	15.0	0	Ажлын гүйцэтгэл 100%	15	15	Ардын хувьсгалын 100, 101 жилийн ойн баярыг угтаж цэнгэлдэх хүрээлэнд засвар хийж, Цэнгэлдэх хүрээлэнгийн индэр хэсгийн тохижилтыг шинээр хийж, 5 хаалганд гагнуур хийж, нугас, цоожийг сольсон. 50 гаруй цонхны хагарсан шилийг шинэчилж, зүлэг усалгааны худгийн моторыг сольсон.	100

Дүн

98

Зорилго 2.3.Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.

17	АЗДҮАХ 2.3.5.1	"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	100.0	Арга хэмжээ боловсруул агд сан.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	100	73.1	Улсын олимпиадын 2-ын давааг 9 судлагдахууны 36 чиглэлээр зохион байгуулж, 30 сургуулийн 6-12 дугаар ангийн 337 багш, 665 суралцагч оролцсон ба медальт байрт шалгарсан 81 суралцагч, 27 багшид 2,970 сая, энэ хичээлийн жилд ЭЕШ-д 2413 шалгуулагч шалгагдсанаас 700-800 оноо авсан 41 суралцагч, бэлтгэсэн шавь нь 800 оноо авсан 3 багш тус бүрийг Засаг даргын Жуух бичиг, 200.0 мянган төгрөг нийт 8.8 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежийн багш, суралцагчдыг Олон улсын өсвөрийн хөгжимчдийн "НАЙДАЛ-2022" уралдаанд оролцоход 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 4 суралцагч эхний байрт шалгарч, 8 багш мэргэжил боловсролоо дээшлүүлсэн байна. Улаанбаатар хотоос ирж ЖЦС-д ажилласан англи хэлний ментор багшийн байрны түрээсэнд 1.0 сая, ээлжит хичээлийн цахим контентын сан бүрдүүлэхэд 1,344 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээ. Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан "Хөдөөгийн багш нарын спортын XIX наадам"-д оролцож багш нарт 3.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 42 хүн оролцож, эрэгтэй шатар 1-р байр, эмэгтэй шатар 4-р байр, эрэгтэй сагсан бөмбөгийн баг 4-р байрыг эзэлсэн байна. Улаанбаатар хотод зохион байгуулагдсан СУИС-ийн салбар ХБК-ийн "Эгшиглэхүйн Эхлэл" сургууль сургалчлах тайлан тоглолтын зардалд 8.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 90 багш ажилтан оролцож, ДБЭТ-1 удаагийн тоглолтыг 550 хүнд толилуулсан байна. Аймгийн ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрын багш, хүүхдийн өөрөө удирдах байгууллагын сургагч хүүхдийг чадавжуулах сургалтын зардалд 1.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Монголын багш нарын баярыг угтан зохион байгуулсан аймгийн Засаг даргын нэрэмжит Урлаг спортын анхдугаар наадмын спортын 7 төрөлд 36 багийн 1254 тамирчин, Урлагийн 5 төрөлд 810 багш оролцож, 32.7 сая дэмжлэгийг үзүүлж, "Чадварлаг багш" арга хэмжээнд нийт 64,314 сая төгрөгийг зарцуулсан байна. Энэ хичээлийн жилд Монгол Улсын Зөвлөх багшийн зэргийн шалгуурыг 8 багш (ЕБС-8, СӨБ-2) хангалаа. Аймгийн ЕБС, СӨБ-ын хөгжмийн багш нарын мэргэжил арга зүй дээшлүүлэх сургалт, ЕБС-ийн бага боловсрол, монгол хэл бичгийн багш нарт "Монгол бичиг минь" сургалт, Боловсролын байгууллагын багш, ажилтны "Ес зүйн хандлага, сайн чанарт сургах" сургалт, ЕБС, цэцэрлэг, дотуур байрын тогооч нарыг чадавжуулах сургалтуудыг зохион байгуулахаар бэлтгэл хангагдсан, нэгж хичээлийн "MEDLE.MN цахим сургалтын нэгдсэн систем"-д ээлжит хичээлийн 130 контент байршуулж, нийтийн хүртээл болгож байгаа 41 багшийн 10 багийг зөвөрийн 10 компьютерээр шагнаж урамшуулахад 19, 0 сая төгрөгийг зарцуулсан.	100
18	АТЖҮЧ 2.1.2 АЗДҮАХ 2.3.2.2	Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	15.0	483.1 оноо	490 оноо	15	15	Элсэлтийн ерөнхий шалгалтын оноог нэмэгдүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах ажлын хэсгийг захирамжаар байгуулж, шалгалтад бэлтгэх, багш суралцагчдыг хөгжүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааны зардалд 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, БШУГ-ын мэргэжилтнүүд 6 бүсэд ажиллаж, 700 гаруй суралцагчдад зөвлөн туслах үйл ажиллагаагаар 1147 цагийн давтлага, сургалтыг зохион байгуулахад 5 ментор багш ажиллаж, 165 багш, удирдах ажилтан хамтран ажилласан байна. Үр дүнд: Элсэлтийн ерөнхий шалгалтанд 859 төгсөгч 10 судлагдахуунаар 2413 шалгалтыг өгч, хэмжээст онооны дундаж 509.4 болж, өмнөх он (494,8) -оос 14.6-аар нэмэгдсэн байна. Элсэлтийн ерөнхий шалгалтанд 700-800 оноо авсан 41 суралцагч, бэлтгэсэн шавь нь 800 оноо авсан 3 багш тус бүрийг Засаг даргын Жуух бичиг, 200.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулахад 8.8 сая төгрөгийг зарцууллаа. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх ажлын хүрээнд "Ахмад настны зөвлөх үйлчилгээний хөтөлбөр"-ийн ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг боловсролын салбарт хэрэгжүүлэхээр аймгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зөвлөлөөс шийдвэрлэсний дагуу 23 ахмад мэргэжилтнээс 12 багш Улиастай, Түдэвтэй, Тосонцэнгэл, Яруу, Идэр, Шилүүстэй сумдад нийт 1960 цагийн зөвлөх үйлчилгээ үзүүлж, ХЭДС-аас 8,820 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
19	АТЖҮЧ 2.1.2 АЗДҮАХ 2.3.3.5	Тосонцэнгэл сумын ЕБ-ын 1, 2- р сургуулийн англи хэлний танхимыг тохижуулна	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	20.0	0	Ажлын гүйцэтгэл 100%	20	20	Тосонцэнгэл сумын 1-р сургууль "Актив өгөгдөл" ХХК-тай гэрээ байгуулж, 3 нэр төрлийн 14 тоног төхөөрөмж (проектор 4, дэлгэц 4, спикер 6) , Тосонцэнгэл сумын 2-р сургууль "Мөнх Өвөгдин" ХХК-тай гэрээ байгуулж, 6 нэр төрлийн 29 тавилга, тоног төхөөрөмж (Пентаблет 10, зурагт 1, принтер 3, сургагч ширээ сандал 9, бичгийн шкаф 2, спикер 4) худалдан авч, сургалтад хэрэглэж байна.	100
20	АТЖҮЧ 2.1.2 АЗДҮАХ 2.3.3.5	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн /Алдархаан сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	20.0	0	Ажлын гүйцэтгэл 100%	20	20	Технологийн кабинетэд 10.0 сая төгрөгийн өртөг бүхий 15 нэр төрлийн 340 ширхэг технологийн сургалтын хэрэгжлэгдэхүүн, багаж, тоног төхөөрөмж нийлүүлэгдэж, сургалтад ашиглагдаж байгаа ба англи хэлний кабинет тохижуулахад "Faro foundation Mongolia" ХХК-тай гэрээтэй ажиллаж, Сандал, ширээ 20 , таблет 20 , зурагт 1 худалдан авсан ба кабинетын засварыг хийгдэж дууссан.	100

21	АЗДҮАХ 2.3.2.2	Ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдын солилцоо арга хэмжээ хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	8.0	0	Алдархаан сумын ЕБС-ийн багш сурагчид хамрагдана.	8	8	"Хүүхэд хөгжүүлэх сургуулийн хөтөлбөрийн менежмент" сургалтыг зөвлөх багш, доктор Б.Насанбаярын 9 удаагийн онлайн сургалтад 153 багш, 3 өдрийн танхимын сургалтын 1 дахь өдрийн сургалтад 25 багш ажилтан оролцож, судлагдахуун бүрийн хөтөлбөрийг шинэчлэн сайжруулж, хичээл сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна, 2 дахь өдрийн сургалтад 156 суралцагч, 3 дахь өдрийн сургалтад 67 ачаагч, ард иргэд оролцож мэдлэг мэдээллээ дээшлүүлсэн байна. Багш солилцоо хөтөлбөрийн хүрээнд маршал Ю.Цэдэнбалын нэрэмжит Увс аймгийн Улсын тэргүүний лаборатори 1 дүгээр цогцолбор сургууль болон 6-р сургуулийн сургалтын үйл ажиллагаатай танилцаж, туршлага судлах 4 хоногийн аялал сургалт хийж, 23 багш, ажилтан хамрагдлаа.	100
22	АЗДҮАХ 2.3.2.2	Иргэдийг соён гэгээрүүлэх сургалт зохион байгуулна /Алдархаан сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	10.0	0	Сумын нийт хүн амын 50-аас доошгүй хувь	10	10	Алдархаан сумын 6 багт "Хамжихгүй бол амжихгүй" сургалтыг зохион байгуулж, 217 иргэн, төрийн албан хаагчдад "Ёс зүй" сургалтыг сэтгэл судлаач Б.Энхцэцэг багштай хамтран 2 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 147 албан хаагч, "Үнэт зүйл ба аз жаргал" сургалтыг Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж, 83 төрийн албан хаагч болон иргэд, Б.Насанбаяр (Ph.D) багштай хамтран зохион байгуулсан "Боловсролын түүчээ" сургалтад давхардсан тоогоор 200 багш, ажилтан хамрагдсан байна.	100
23	АТЖҮЧ 2.1.2 АЗДҮАХ 2.3.3.5	Тэс сумын хүүхдийн цэцэрлэгийн гал тогоо тоног төхөөрөмжөөр хангана.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	10.5	0	Ажлын гүйцэтгэл 100%	10.5	10.5	Худалдан авах эрхийг сумд шилжүүлж, "Тэс Борхын шугуй" ХХК-тай гэрээ байгуулж, гал тогооны шүүгээ, агшин зуур халаагч, аяга хатаагч, мах, жимсний миксер, ажлын ширээ зэрэг тоног төхөөрмжийг нийлүүлсэн байна.	100
24	АТЖҮЧ 2.1.2 АЗДҮАХ 2.3.3.5	Насан туршийн боловсролын төвийн үйл ажиллагааг дэмжинэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	30.0	0	Гүйцэтгэл 100%	30	29.79	Насан туршийн боловсролын төвд шаардлагатай тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж, тендэрт "Санаа мед трейд" ХХК шалгарч, гэрээ байгуулагдан 19 төрлийн 29 сая 790 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.	100
25	АТЖҮЧ 2.1.3 АЗДҮАХ 2.3.3.5	Багш хөгжлийн жишиг төв байгуулна /Баянтэс, Дөрвөлжин, Идэр, Нөмрөг, Сантмаргаз, Шилүүстэй, Түдэвтэй, Тэлмэн, Тэс, Сонгино, Яруу сумын ЕБС, Улиастай сумын 1,4,9-р цэцэрлэг, Тосонцэнгэл сумын хүүхдийн цэцэрлэг/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	150.0	8	11 сургууль, 4 цэцэрлэг	150	150	Багш хөгжлийн жишиг төв шаардлагатай тавилга, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж, тендэрт "Зост өргөө" ХХК шалгарч, аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, худалдан авалт хийгдэж, Баянтэс, Дөрвөлжин, Идэр, Нөмрөг, Сантмаргаз, Шилүүстэй, Түдэвтэй, Тэлмэн, Тэс, Сонгино, Яруу сумын ерөнхий боловсролын сургууль, Тосонцэнгэл сумын 6 дугаар цэцэрлэг болон Улиастай сумын 1,4,9 дүгээр цэцэрлэгийн "Багш хөгжлийн төв"-д нийлүүлэгдэж байгаа 16 төрлийн тавилга, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.	100
26	АЗДҮАХ 2.3.3.6	Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинэчилнэ. /Завханмандал, Отгон, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сонгино сумын ЕБС, Асгат, Нөмрөг, Улиастай сумын 6-р цэцэрлэг/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	120.0	-	5 сургууль, 3 цэцэрлэг	120	120	Завханмандал, Отгон, Эрдэнэхайрхан, Цэцэн-Уул, Сонгино сумын ерөнхий боловсролын сургууль, Асгат, Нөмрөг, Улиастай сумын 6-р цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн судалгааг хүргүүлж, тендэрт "Чиглэл" ХХК шалгаран гэрээ хийгдэж, I, II хоолны тогоо, цахилгаан жигнүүр, цахилгаан пийшин, аяга таваг ариутгагч зэрэг 12 нэр төрлийн 120,0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн байна.	100
27	АЗДҮАХ 2.3.3.4	Дотуур байранд "Хүүхэд хөгжлийн танхим" байгуулна /Их-Уул, Идэр, Сантмаргаз, Тосонцэнгэл сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	40.0	0	4 сумын 250 гаруй хүүхэд хөгжих боломж бүрдэнэ.	40	40	"Хүүхэд хөгжлийн танхим"-д шаардлагатай тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгааг хүргүүлж, тоног төхөөрөмж нийлүүлэх тендэрт "Санаа мед трейд" ХХК шалгарч, гэрээ байгуулагдан 16,661 төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн ба тавилга хэрэгслийг нийлүүлэх тендэрт "Энх-Мөнх Ирээдүй" ХХК шалгаран гэрээ хийгдэж, нийлүүлэгдэж ерөнхий боловсролын 4 сургуулийн дотуур байр жишиг "Хүүхэд хөгжлийн танхим"-тай болж, 4 сумын 250 хүүхдийн хөгжих боломж бүрдсэн байна.	100
28	АЗДҮАХ 2.3.3.4	Дотуур байрны зөөлөн эдлэлийг шинэчилнэ. /Асгат, Завханмандал, Отгон, Тэлмэн, Улиастай сумын лаборатори ЧЭЦС/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	14.0	0	300 гаруй хүүхдийн амьдрах орчин нөхцөл сайжирна.	14	14	Аймгийн Боловсрол шинжлэх ухааны газар Улаанбаатар хотын "Сайн хөнжил" ХХК-тай гэрээ хийж, 14.0 сая төгрөгийн өртөг бүхий хөнжил, гудас, цагаан хэрэглэлийг Асгат, Завханмандал, Отгон, Тэлмэн сумын ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд, БШУГ-аас Тайваны хүүхдийн санд төсөл бичиж хүргүүлсэн төслийн үр дүнгээр Эрдэнэхайрхан, Сонгино, Түдэвтэй сумын сургуулийн дотуур байр, Улиастай сумын ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн дотуур байранд 23.6 сая төгрөгийн өртөг бүхий гудас, хөнжлийг хүлээлгэн өгсөн байна.	100
29	АТЖҮЧ 2.1.3 АЗДҮАХ 2.3.3.5	Цэцэрлэгийн тоног төхөөрөмж, зөөлөн эдлэлийг шинэчилнэ /Улиастай сумын 5 дугаар цэцэрлэг/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	20.0	0	290 гаруй хүүхэд ая тухтай суралцах нөхцөл бүрдэнэ.	20	20	"Мөнхийн алтан тэрэлж" ХХК-тай гэрээ байгуулж, Улиастай сумын 5 дугаар цэцэрлэгт 200, 8 дугаар цэцэрлэгт 100, 6 дугаар цэцэрлэгт 100, 2 дугаар цэцэрлэгийн салбар бүлэгт 71, Идэр сумын цэцэрлэгт 50 ширхэг хос цагаан хэрэглэлийг нийлүүллээ.	100

30	АЗДҮАХ 2.3.2.3	Аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгоно.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	20.0	16 хүүхэд олгосон.	20-оос доошгүй оюутанд олгоно.	20	20	Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг батлагдсан шалгуур үзүүлэлтээр дүгнэж, тэтгэлэгт хамрагдахаар хүсэлт, материалаа ирүүлсэн 43 оюутнаас шилдэг 20 оюутныг шалгарууллаа. МУИС-ийн оюутан Г.Сарнай, Н.Эрдэнэсүрэн, Б.Одончимэг, АШУУИС-ийн оюутан А.Ариунцэцэг, О.Бүрэнцогт, З.Цэнд-Очир, А.Ариунзааяа, Б.Даваажаргал, Б.Бадамцэрэн, СЭЗИС-ийн оюутан Б.Даваадэмбэрэл, М.Пүрэвбаатар, Ж.Цэнд-Аюуш, ХААИС-ийн оюутан Ш.Оюундарь, ДХИС-ийн оюутан Б.Уртнасан, Төмөр замын дээд сургуулийн оюутан Ө.Мөнхзул, Б.Баасандорж, Б.Бямбацэрэн, Этүгэн Их сургуулийн оюутан М.Чанцалноров, М.Ренчинханд, Их Засаг Их сургуулийн оюутан Б.Сарнай нар тус бүр нэг сая төгрөгийн тэтгэлэгт хамрагдаж, Засаг даргын "Батламж" авсан байна.	100
31	АТЖҮЧ 2.1.4 АЗДҮАХ 2.3.3.3	Хүүхэд тээвэрлэх зориулалтын автобусаар хангана /Улиастай сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	100.0	0	1 автобус	100	70	Улиастай сумд хүүхэд тээвэрлэх зориулалтын автобусаар хангах зорилгоор 70.0 сая төгрөгөөр 1 автобус авахаар гэрээ байгуулж, үнийг шилжүүлсэн. Худалдан авалт хийгдсэн байна.	90
32	АТЖҮЧ 2.1.6, АЗДҮАХ 2.3.6.2	Аймгийн Засаг даргын ивээл дор Завхан аймгийг тогтвортой хөгжүүлэх эрдэм шинжилгээний хурал зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	10.0	0	Хөгжлийн бодлого, чиглэлийг тодорхойлно.	10		Завхан аймаг Байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд "Завхан 100" ЭШХ-ыг аймгийн Засаг даргын ивээл дор 2023.01.08-нд Улаанбаатар хотод зохион байгуулж, хуралд Улсын Их хурлын гишүүд, Монгол Улсын анхны ерөнхийлөгч, аймгийн ИТХ-ын дарга, төр нийгмийн зүтгэлтнүүд, эрдэмтэн судлаачид, сумдын Засаг дарга нар, төрийн болон шинжлэх ухааны байгууллагын ажилтнууд зэрэг 100 гаруй хүн оролцлоо. Хуралд 14 илтгэл тавигдаж, аймгийн хөгжлийн бодлого тодорхойлогдсон байна.	100
<b>Дүн</b>											<b>99.38</b>	
Зорилго 2.4.Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн, нийгмийн даатгалын үйлчилгээг сайжруулж, нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэн, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин, амьдралын чанарыг дээшлүүлнэ.												
33	АТЖҮЧ 2.4.5, АЗДҮАХ 2.5.16.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	4.0	2021 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	4	1.3	Нийгмийн халамжийн сангаас 2022 оны жилийн эцсийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх тусламж хөнгөлөлтөд 450 иргэн хамрагдаж 146.7 сая төгрөг зарцуулсан. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний өөрөө өөртөө ажлын байр бий болгох төсөлд 40 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж 78.3 сая төгрөг олгогдсон. Аймгийн төрийн болон төрийн бус байгууллагуудаар үйлчлүүлэх хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хэсгийн орц гарцыг тохижуулан, үйлчлүүлэх нөхцөл боломжоор хангах зорилгоор сумдын Засаг дарга нарт зөвлөмж хүргэснээр 45 байгууллагын орц гарц стандартын дагуу хийгдсэн байна. ХБХ-ийн ЭМБНХСК-ийн хурлаар энэ онд 181 хүүхдийн хөгжлийн бэрхшээлийг тодорхойлж, эрүүл мэнд, боловсрол болон нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрууллаа. хараагүйчүүдийн эрхийг хамгаалах "Цагаан таягтнуудын олон улсын өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэхэд 1.336.0 мянган төгрөг, ХБИ-ийн эхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэхэд 2770.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.	100
34	АТЖҮЧ 2.4.8, АЗДҮАХ 2.5.15	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлыг эрчимжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	3.0	2021 оны төлөвлөгөө 100% хэрэгжсэн	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	3.0	9.0	Жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцсон "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" хэлэлцүүлэг зохион байгуулан, хэлэлцүүлгээс гарсан саналыг Улаанбаатар хотод болон үндэсний чуулганд хүргэн, чуулганаас гарсан зөвлөмжийг орон нутагт түгээн ажиллаж байна. Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх "Харилцан хүндэтгэе" аянд төрийн байгууллагууд идэвхтэй оролцон, хамтран ажилласан. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Жендер ба хүний эрх" сургалтыг 2022 оны 06 сарын 06-нд аймаг сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт, 06 сарын 07-нд төрийн тусгай, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын дарга нарт зохион байгуулсан. Гэр бүлийн гишүүдийн жендэрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл боловсролтой эр хүн жаргалтай гэр бүлийн үндэс" аймгийн эрэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулан, 17 сумын 230 гаруй төлөөлөгч оролцон, эрэгтэйчүүдийн тулгамдсан асуудлуудаар илтгэл сонсож, санал солилцон, зөвлөмж гарган, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэн ажиллаж, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/468 дугаар захирамжаар "Эрчүүдийн зөвлөл" байгууллаа. Эмэгтэйчүүд ба хөгжил сургалтын үйл ажиллагааг 2.7 сая төг, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Халдваргүй монгол эмэгтэй" төслийн нээлт "Улаан цэцэг" арга хэмжээг 6.3 сая төгрөгөөр дэмжин ажилласан.	100
35	АЗДҮАХ 2.5.12.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төв байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	4.0	-	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	4		Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч хөгжих эрхийг хангах зорилгоор Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийн төвийг бэхэлгээтэй алуулагч, тэргэнцэр, зогсоогч зэрэг хэрэглээг хангаж, 4,0 сая төгрөгийг зарцуулсан.	100
	АТЖҮЧ				ТХ	427.2					"Тогтвортой амьдрал-Амгалан гэр бүл" арга хэмжээний хүрээнд: Гэр бүлийн үнэ цэнийг бэхжүүлэх, хөгжлийг дэмжих лекц сургалт, чуулган, уулзалт хэлэлцүүлэг, уралдаан тэмцээн, нөлөөллийн арга хэмжээ зэрэг 81 удаагийн үйл ажиллагаанд нийт 4424 хүн хамрагдсан. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хамтын хүч-Хөгжлийн гарц" нэгдсэн наймдугаар чуулганы үйл ажиллагааг зохион байгуулахад ОНТ-өөс 18.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, "Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг зохион байгуулахад 10 сая төгрөг зарцуулсан. "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцоо, манлайлал" хэлэлцүүлэг зохион байгуулахад 78.3 сая төгрөг олгогдсон.	

36	2.4.1, АЗДҮАХ 2.5.8, 2.5.8.2	"Тогтвортой амьдрал амгалан гэр бүл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	Арга хэмжээ батлагдсан	6226 хүнд хүрч ажиллана.		ОНТ 27.3	Тохиолцуулан 10 залуу гэр бүлийг оролцуулсан явган сувиач хатан сүхх гэрлэлтийн батлах гардуулах ёслолыг зохион байгуулж, гэрлэлтийн батлах гардуулах ёслолд оролцсон хосуудыг гэр бүлээ батлуулах ёслолын өмнө "Гэр бүлийн үнэ цэнэ, хосуудын харилцаа" сэдэвт сургалтанд хамруулж, ОУ-ын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан Улиастай сумын 6 багийн зорилгод бүлгийн эмэгтэйчүүдэд "Эмэгтэйчүүд ба хөгжил" сургалт зохион байгуулан ОНТ-өөс 2.7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Мөн Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан үйл ажиллагааны зардалд ОНТ-өөс 2.1 сая төгрөгийн, "Эрүүл боловсролтой эр хүн жаргалтай гэр бүлийн үндэс" сэдэвт аймгийн эрэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулж ОНТ-өөс 4.5 сая төгрөгийн дэмжлэг тус тус үзүүлсэн байна.	100
37	АЗДҮАХ 2.2.2	"Даян мэргэн" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ТХ	30.0	Арга хэмжээ батлагдсан (8)	16	ТХ 30.0	ТХ 64.9 ОНТ- 9.8	2022 онд Аймгийн засаг даргын нэрэмжит аймгийн аварга шалгаруулах шагайн харвааны шилжин явах цомын тэмцээнд 17 багийн 156 харваач оролцсон байна. Өсвөрийн аварга шалгаруулах шагайн харвааны тэмцээн анх удаагаа зохион байгуулагдаж нийт 15 багийн 96 харваач оролцсон. Даян мэргэн" арга хэмжээний хүрээнд нийт 74.7 сая төгрөгийн санхүүжилттэй 17 төрлийн тэмцээн, уралдаан, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулж, ОНТ-өөс 9.8 сая төгрөгийн дэмжлэг, төсөл хөтөлбөрөөс 64.9 сая төгрөгийн санхүүжилт авч ажилласан байна. Мөн уг арга хэмжээний хүрээнд Сартуул шагайн харвааг сэргээн дэлгэрүүлэх, Очирваанын тойром харваа наадмыг шинээр үүсгэн дэглэн зохион байгуулсан.	100
38	АТЖҮЧ 2.4.2 АЗДҮАХ 2.5.9	Оны шилдэг хүүхэд, хүүхдийн оролцооны байгууллага, нийгмийн ажилтан, гэр бүлийг шалгаруулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	9	9	5	ОНТ-5.0	Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/620 дүгээр захирамжаар "Аймгийн оны тэргүүний шилдэг хүүхэд, хүүхдийн оролцооны байгууллага, нийгмийн ажилтныг шагнаж урамшуулахад зориулж 5,000,000 (таван сая)" төгрөгний дэмжлэг үзүүлж хамтран ажиллаа. Аймгийн 2022 оны тэргүүний шилдэг хүүхэд, хүүхдийн оролцооны байгууллага, нийгмийн ажилтныг шагнаж урамшуулах үйл ажиллагаанд нэр дэвшигчдийн материалыг ГБХЗХГ-т хүлээн авч ажлын хэсэг шалгаруулан, 13 төрлөөр шалгаруулан шагнаж урамшуулсан байна.	100
39	АЗДҮАХ 2.5.8.1, 4.2.2.1	Завхан аймагт шилжин ирсэн иргэдийн тогтвор суурьшилтай ажиллаж, амьдрахад чиглэсэн үйлчилгээг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ТХ	20.0	40 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлсэн.	190 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна.	давхардсан тоогоор 903 хүн сургалт, сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан.	10.2	НҮБ-ын Шилжилт хөдөлгөөний байгууллага (ИОМ)-ын санхүүжилтээр "Сэтгэлийн гоёл" ТББ - аас хэрэгжүүлж буй "Завхан урлал" шилжин суурьшигчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бичил төслийн хүрээнд 720 гаруй иргэнд шилжилт хөдөлгөөний талаар мэдээлэл сургалт хийж, эрх зүйн болон сэтгэлзүйн зөвлөгөөг 72 иргэнд өгсөн. Мөн шилжин суурьшигчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор "Саван хийх" сургалтад шилжиж ирсэн 20 иргэн, модон эдлэлийн сургалтад шилжиж ирсэн 8 иргэн, гар урлалын сургалтад 10 иргэн, нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хөдөлмөр эрхлэлтэд бэлтгэх сургалтад 36 иргэн, нэхмэл гутлын сургалтад 15 иргэн, давсан урлалын сургалтад 12 иргэн, эпокси (шингэн шилэн урлал) урлалын сургалтад 10 хүн тус тус хамруулсан. Сургалтын үр дүнд модон эдлэлийн сургалтад хамрагдсан 2 иргэн модон эдлэл /сандал/ хийн худалдаалж өрхийн орлогоо нэмэгдүүлсэн байна. Сургалтад хамрагдсан иргэд хувиараа гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэн өрхийн орлогоо нэмэгдүүлж байна.	100
40	АТЖҮЧ 5.2.2 АЗДҮАХ 4.2.2.1	Аймгийн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд хүний эрхийг хангахад чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа явуулна.	2022	АЗДТГ-ын НБХ, ХОХБТХ, ХЭЗХ	ТХ	5.0	Бизнесийн байгууллагын 300 ажилтан, ажил олгогчидод сургалт, 500 иргэнээс судалгаа авсан.	Бизнесийн байгууллагын 300-аас доошгүй ажилтан албан хаагчдад хүний эрх, хөдөлмөрийн эрх зүйн сургалт хийнэ.	5	60	Зээлийн батлан даалтын сангийн Гүйцэтгэх захирал Ш.Алтанчимэг, Завхан аймгийн удирдлагууд, Завхан аймаг дахь арилжааны банкуудын захирал, зээлийн эдийн засагч нар, 35 аж ахуй нэгжийн төлөөлөл, 315 бизнес эрхлэгчдэд 21 удаагийн сургалт уулзалтыг зохион байгуулсан. Төсөл хөтөлбөрөөс 3.5 сая төгрөг зарцуулсан. "Батлан даалттай эзэлд хэрхэн хамрагдах вэ?" сэдвээр сургалтыг зохион байгуулж 35 аж ахуйн нэгжийн төлөөллийг хамруулсан. Best сургалтын төвөөс хоршооны засаглал, ЖДБ-ийн компанийн засаглал, Санхүүжилтийн боломж, Дижитал маркетинг, 24 сумдын худалдаа эрхлэгчдийг чадавхжуулах зэрэг сэдвээр 22 удаагийн сургалт, уулзалтыг 600 гаруй бизнес эрхлэгч нарт хүргэсэн байна. АНУ-ын хөгжлийн агентлагийн санхүүжилттэйгээр Хөгжлийн шийдэл ТББ-аас эрхлэн жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх, зээлийн батлан даалтын сангаас аж ахуй эрхлэгчдэд ямар зэр олгогддог, мөн хүний эрхийн чиглэлээр сургалт, хэлэлцүүлэг, ярилцлага, уулзалт, форм зэрэг 49 үйл ажиллагаанд 740 оролцогч оролцон, 60.0 сая төгрөгийг зарцуулсан байна.	100
41	АЗДҮАХ 2.5.15.1	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	3.0	1	3	0	26.5	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил, малчин, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөлөл оролцсон "Нийгмийн хөгжилд эрэгтэйчүүдийн оролцоо, манлайлал" хэлэлцүүлэг зохион байгуулан, хэлэлцүүлгээс гарсан саналыг Улаанбаатар хотод болсон үндэсний чуулганд хүргэн, чуулганаас гарсан зөвлөмжийг орон нутагт түгээн ажиллаж байна. Жөндөрт суурилсан хүчирхийлэлээс урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэгийг олон нийтэд хүргэх "Харилцан хүндэтгэе" аянд төрийн байгууллагууд идэвхтэй оролцон, хамтран ажилласан. Завхан хийморь эрчүүд НҮТББ-ын үйл ажиллагааг дэмжих ОНТ-өөс 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний комисс, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран "Жөндөр ба хүний эрх" сургалтыг 2022 оны 06 сарын 06-нд аймаг сумын ИТХ-ын дарга, Засаг дарга нарт, 06 сарын 07-нд төрийн тусгай, төрийн захиргаа, төрийн үйлчилгээний байгууллагын дарга нарт зохион байгуулсан. Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор "Эрүүл боловсролтой эр хүн жаргалтай гэр бүлийн үндэс" аймгийн эрэгтэйчүүдийн зөвлөгөөнийг зохион байгуулан, 17 сумын 230 гаруй төлөөлөгч оролцон, эрэгтэйчүүдийн тулгамдсан асуудлуудаар илтгэл сонсож, санал солилцон, зөвлөмж гарган, төрийн болон төрийн бус байгууллагад хүргүүлэн ажиллаж, аймгийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн А/468 дугаар захирамжаар "Эрчүүдийн зөвлөл" байгууллаа. Зөвлөгөөнийг зохион байгуулахад ОНТ-өөс 4.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв. Гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсөд эрх зүйн туслалцаа үзүүлэх НЦҮТ-өөр эрсдэлт нөхцөлд байгаа 53 иргэнд үйлчилгээ үзүүлсэн байна. Аймгийн Засаг даргын захирамжаар НЦҮТ-ийн үйл ажиллагаанд 20.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна.	100

42	АЗДҮАХ 4.2.2	Улаан загалмайн хороотой хамтарч ажиллана.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	8.0	1	1	8	5	Төр, улаан загалмайн хамтын ажиллагааны хүрээнд анхан шатны хорооны гишүүдийг чадавхжуулах, зорилгод бүлгийн иргэдэд нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, зөв амдралын дадал хэвшил олгох сургалт нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 5.0 сая төгрөгийг зарцуулсан. Арга хэмжээнд анхан шатны хорооны нарийн бичгийн дарга 15, Улиастай сумын 6 багийн 50 иргэн тус тус хамрагдсан. Сургалт нөлөөллийн арга хэмжээний хүрээнд Эрүүл хооллолтын хөтөч, Таван махбодийн онол, угайр бичиг хөтлөхийн ач холбогдол зэрэг сургалт мэдээллийг хүргэж, өсвөрийн Улаан загалмайч хүүхдүүд өөрсдийн бэлтгэсэн тоглолтыг үзүүлж, ахмад настнуудтай ярилцаж амьдралын түүхийг нь сонсон тэдний сургаалаас суралцсан.	90
<b>Дүн</b>											<b>98.89</b>	
Зорилго 2.5.Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлж, "Үндэсний бахархал Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ.												
43	АТЖҮЧ 1.1.5, 1.1.6, АЗДҮАХ 2.6.1.3	Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар их наадмыг зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	0	100-аас доошгүй иргэн оролцоно.	5	5	"Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар наадам"-ыг зохион байгуулахад орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөгийг зарцуулж, аймгийн Соёлын биет бус өвийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй 16 сумын 131 өвлөн уламжлагч оролцож, оролцсон сумдыг 7 ай савыг хамруулсан байдал, үзэсгэлэнд оролцсон байдал зэргийг нь харгалзан үзэж шилдэг 3 сумыг шалгаруулж Өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. Тэргүүн байранд Их-Уул, дэд байранд Отгон, Гутгаар байранд Тосонцэнгэл сум шалгарч Өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа. Соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын анхдугаар их наадмын хүрээнд шинээр бүртгэн баримтжуулсан болон аймгийн бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй, үр чадварын өндөр түвшинд эзэмшсэн 130 өвлөн уламжлагчдад үнэмлэх, батламж олголоо. Анхдугаар наадмаас шалгарсан 43 өвлөн уламжлагч соёлын биет бус өвийн 7 ай савын 58 төрлөөр Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Нүүдэлчин монгол-2022" дэлхийн соёлын фестивалд оролцож, Тосонцэнгэл сумын өвлөн уламжлагч Д.Даваарагчаа, Улиастай сумын өвлөн уламжлагч Р.Хашбат, Б.Мөнхтуяа нар Монгол улсын шилдэг өвлөн уламжлагчаар шалгарсан. "Нүүдэлчин монгол-2022" дэлхийн соёлын фестивалд оролцогчдод орон нутгийн төсвөөс 10,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100
44	АЗДҮАХ 2.6.4.1	Алдархаан сумын Ямаан усанд Хүннүгийн үеийн булшны археологийн малтлага хийнэ	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	40.0	-	Ажлын гүйцэтгэл 100%	40	40	ШУТИС-ийн археологийн судалгааны баг, Ямаан ус-1 хэмээх оршуулгын газарт нийт 150 орчим булш тоологдсон ба Ямаан усны Хүннүгийн дурсгалт газарт 2 булш сонгон малтлага судалгааг хийж дурсгалаас сүйх тэрэгний модон тэвш, тэрэгний эд ангиуд, хүрэл болон шавар сав суулга, төмөр эдлэл, даавуу, чулуун эдлэл, хүн малын яс зэрэг олон арван үнэт олдворыг олж нээсэн. Эдгээрийн дотор хүрэл сангийн бойлоор, модон сац зэрэг нэн ховор эд өлгийн зүйлс илрүүлсэн байна. Мөн авсны тагны хээ чимэглэлийг бүтэн байдлаар баримтжуулсан нь Монголд хийгдсэн анхны тохиолдол болж байна.	100
45	АЗДҮАХ 2.6.4.1	Үндэсний бахархал Монгол өв соёл арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	40.0	-	Ажлын гүйцэтгэл 100%	40	40	Үндэсний бахархал, Монгол өв соёл арга хэмжээг хэрэгжүүлэн Завхан аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг угтаж, Завхан аймгийн Бурхан шашинтны төв Төгс буянт Жавхлант хийдээс санаачлан, Аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Очирваанийн хувилгаад, хамба нарын номын айлдвар" арга хэмжээг Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул сумдад зохион байгуулж 850 гаруй иргэд оролцлоо. Үргэлжлэн Улиастай сумын ЕБСургууль, Их дээд сургуулийн оюутан сурагчдад соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	100
46	АТЖҮЧ 2.4.2 АЗДҮАХ 2.6.7	Хүүхдийн ардын урлаг, соёлын "Яргуй-2022" наадам зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	0	Аймгийн 29 сургууль хамрагдана.	5	5	Аймгийн Засаг даргын захирамжаар Хүүхдийн урлаг, соёлын "Яргуй-2022" наадмыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төсвийг баталж, наадмыг зохион байгууллаа. Тус наадамд аймгийн ерөнхий боловсролын сургууль, төрийн болон төрийн бус байгууллагын дэргэдэх клубын 800 гаруй суралцагчид доорх 5 төрлөөр (Монгол ардын дуу (ардын богино дуу, уртын дуу, харилцаа дуу), Монгол ардын бүжиг (гоцлол болон хамтлаг), Монгол ардын хөгжим (гоцлол болон хамтлаг), Ардын язгуур урлаг (ардын аман зохиол, ерөөл, магтаал), Монголын уламжлалт шайган наадгай (хасаа харваа, шайгай шүүрэх) оролцлоо. Наадмыг шүүх шүүгчдийг аймгийн Засаг даргын захирамжаар томилж, хариуцлагын гэрээ хийж, шүүгчдээр Хөгжимт жүжгийн театр, Соёл урлагийн Их сургуулийн салбар Хөгжим бүжгийн коллежийн багш нар ажиллалаа. 114 суралцагч шагналт болон медальт байранд, багийн дүнгээр Лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн хамт олон тэргүүн байрт шалгарлаа.	100
47	АТЖҮЧ 1.1.5, АЗДҮАХ 2.6.2	"Бадархундага" яруу найргийн наадам зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	8.0	120	150-аас доошгүй яруу найрагчийг оролцуулна.	8	12	"Бадархундага-2022" яруу найргийн их наадам 2022 оны 11 сарын 21 -ний өдөр Улаанбаатар хотноо амжилттай байгуулсан. Тус наадмын нэгийн даваанд нийт 92 яруу найрагч шүлгээ ирүүлсэн бөгөөд хоёрын даваанд 30 найрагч шүлгээ дуудаж, яруу найрагч А.Бөхням тэргүүн байр эзэлж, "Болор цом-40" яруу найргийн наадамд оролцох эрхээр шагнагдсан Яруу найргийн наадамтай хамтатган Завхан аймгийн Зохиолчдын чуулга уулзалтыг хийж, 100 гаруй зохиолчид оролцсон байна.	100
48	АТЖҮЧ 1.1.7, АЗДҮАХ 2.6.7.1	Соёлын төвийн техник хэрэгсэл /Тэлмэн, Сантмаргаз, Түдэвтэй сум, Хилийн цэргийн 0277 дугаар анги/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	40.0	18	22	40	40	Шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлж, тендэрт "Цуурай" ХХК шалгарч, гэрээ байгуулан 2022 оны 07 сарын 07-нд 13 нэр төрлийн 39 ширхэг техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн.	100

49	АТЖҮЧ 1.1.4, АЗДҮАХ 2.6.5	"Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр II" -ыг хэрэгжүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт 90% байна.	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	5	5	"Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр 3" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Хос бичигтэн" хоёр сарын аянд ЕБС-ийн 6-12 дугаар ангийн суралцагчид, монгол хэл, уран зохиолын багш нар, монгол бичиг сонирхогчид, Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд олон нийтийг хамруулах зорилгоор тодорхой чиглэлүүдийг зааж, мэдээллийг албан байгууллага, аж ахуйн нэгжид албан бичгээр хүргүүлж, үр дүнг "Завхан-Эх хэл бичгээ эрхэмлэе" цахим сүлжээнд байршуулан дүгнэж, шилдэг оролцогчдыг шагнаж урамшууллаа. Аймгийн ерөнхий боловсролын сургуулиуд болон боловсролын байгууллагуудын Монгол хэл, бичиг, уран зохиолын багш нарын дунд зохион байгуулсан "Хөрвүүлэгч"-ийн уралдааны шилдэг өгүүллэгүүдийг эмхэтгэн хэвлүүлэх зардалд шаардагдах 2.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, 23 багшийн 26 өгүүллэгийг эмхтгэн 200 ширхэг номыг хэвлүүлж, багш суралцагчдад хүргүүлээ.	100
50	АТЖҮЧ 1.1.2, АЗДҮАХ 2.6.3.1	Соёлын төвийн номын сангийн тохижилт /Андархаан сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	10.0	-	Ажлын гүйцэтгэл 100%	10	10	Арт мебель тавилгын үйлдвэртэй гэрээ байгуулж, номын төмөр тавиур 6, ханын тавиур 4, 4 хүний ширээ 2, кофены дугуй ширээ 2 сандлын хамт, тайзны гэрэлтүүлгийн зам, жижиг чимэглэл нийлүүлэгдэж, тохижилтын ажил хийгдсэн.	100
51	АТЖҮЧ 1.1.2, АЗДҮАХ 2.6.3.1	Номын сангийн цахим сан, фондыг баяжуулна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	5.0	-	Тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт 100%	5	5	Номын сангийн цахим сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн ууган хэвлэл болох Туяа сонины 1946-1990 он хүртэлх дугаарууд нийт 9933 нүүрийг Омега программд оруулж сонин хэвлэлийн 87% ийг цахимжуулаад байна. Мөн уншлага үйлчилгээний зарим нэр төрлийг сайжруулах зорилгоор уншлагын Galaxy Tab A7 худалдан авч цахим ном суулуулах бэлтгэлийг хангаад байна. Номын сангийн интернэтийн хурд удаан цахим ном уншлага явагдах боломж хомс байдаг тул "Гайхмаар хурд" ХХК-наас интернэтийн хурдыг 4GB-аар өсгөн авч ашиглаж байна. Мөн гадаад уншлагын хурдыг нэмэгдүүлэх зорилгоор Лингорс байгууллага, Xreading цахим номын сантай хамтран нийт 35 уншигч хүүхдүүдийг гадаад уншлагын марафонд оролцуулаад байна.	100
52	АТЖҮЧ 1.1.6 АЗДҮАХ 3.7.3	Орон нутаг судлах музейн барилгын цахилгааны засвар /Улиастай сум/	2022	АЗДТГ-ын НБХ	ОНХС	30.0	-	Ажлын гүйцэтгэл 100%	30	30	"Товчог бурхант" ХХК тендерт шалгарч, гэрээ хийгдэн музейн үзүүлэлийн 10 танхим, ажилчдын 2 өрөө, үүдний 1 өрөөний цахилгааны засварыг хийж гүйцэтгэсэн байна.	100
<b>Дүн</b>											<b>100</b>	
Зорилго 2.6. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчлан, иргэдэд түгээнэ.												
53	АЗДҮАХ 4.2.8	Орон нутагт зохион байгуулж буй онцлог үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд сурталчилна.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	25.0	50	Аймгийн нийт иргэдэд мэдээ мэдээллийг тухай бүр хүргэнэ.	25	25	Завхан аймагт болж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ард иргэдэд чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэхийг зорин ажиллаж байна. 2022 онд орон нутагт зохион байгуулж буй онцлох үйл явдлын 350 гаруй мэдээллийг бэлтгэж, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз болон орон нутгийн телевизүүд цахим сайтуудаар нэвтрүүлж, сонин сэтгүүлд нийтлэн улс орон даяар сурталчилж ажилласан.	100
54	АЗДҮАХ 4.2.8	Орон нутгийн мэдээ мэдээллийг ДДШТВ-ийн "AIR1", "Шинэ Завхан" сувгаар дамжуулан 24 суманд нэвтрүүлнэ.	2022	АЗДТГ-ын НБХ	ОНТ	12.0	2	Мэдээ мэдээлэл 24 сумын нийт иргэдэд хүрэх нөхцөл бүрдэнэ.	12	12	ДДШШ ТВ-ийн сувгаар орон нутгийн мэдээ мэдээллийг 24 сум, бусад аймгуудад нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллалаа.	100
<b>Дүн</b>											<b>100</b>	
<b>ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮН</b>											<b>99.38</b>	
<b>Бүлэг 3. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>												
Зорилго 3.1.Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрт хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно.												
55	АЗДҮАХ 3.1.2.3	Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг зохион байгуулна.	2022	АЗДТГ-ын СТСХ	ОНТ	8.0	2	Хамрагдвал зохих өрх, мал, тэжээвэр амьтад, хашаа худгийг үнэн зөв бүрэн хамруулна.	8	3	Хагас жилийн малын түүвэр судалгааг аймгийн Засаг даргын 2022 оны 4 дүгээр сарын 18-ны өдрийн А/208 дугаар захирамжаар тооллогын комисс байгуулагдан 6 дугаар сарын 15-аас 7 дугаар сарын 4-ны хооронд хөдөө аж ахуйн тооллоготой хамтатган таблет ашиглан цахимаар зохион байгуулсан. Хагас жилийн малын түүвэр судалгаагаар сум бүрд тооллогын комисс байгуулан 2021 оны жилийн эцсийн мал тооллогоор тоологдсон малтай өрхийн 30 хувийг хамруулж хугацаанд нь амжилттай зохион байгуулсан. 2022 оны жилийн эцсийн мал тооллогын ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг аймгийн Засаг даргын 2022 оны 11 сарын 30-ны өдрийн А/590 тоот захирамжаар батлан, төлөвлөгөө гарган, комиссын гишүүдэд хариуцуулан биелэлтэнд нь хяналт тавих ажлыг зохион байгуулсан.	100
